



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 01 сарын 27 өдөр

Дугаар A/09

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15, 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хувийн ажлын зохион байгуулалт, цагийн менежмент” сэдэвт сургалтыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, шинээр томилогдсон хороодын Засаг дарга нарт 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр дүүргийн иргэний танхимд зохион байгуулсугай.

2. Сургалт зохион байгуулах ажлын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Сургалтыг удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Т.Сүхбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.БАЯРАА



1180200054



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сар-Цагаан сарын шинийн нэгний баярыг тохиолдуулан Засаг даргын Тамгын газраас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардал 4.970.000 /Дөрвөн сая есөн зуун далан мянган/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргахыг Тамгын газрын ахлах нягтлан бодогч /Г.Золзаяа/-д зөвшөөрсүгэй.

3. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Т.Сүхбаатар/, Аж ахуйн тасаг /З.Батдэлгэр/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  М.БАЯРАА



1180200108



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/13.

Улаанбаатар хот

┌ Буцалтгүй тусламж үзүүлэх тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засаг даргын Тамгын газрын дотоод журмын 16.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн бичээч Оргодолын Нарантуяагийн эмээ С.Цэрэвхүү нь нас барсан тул О.Нарантуяад нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Тусламжинд шаардагдах 480.000 /Дөрвөн зуун наян мянган/ төгрөгийг Тамгын газрын нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлаас гаргахыг Тамгын газрын ахлах нягтлан бодогч /Г.Золзаяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  М.БАЯРАА



1180200092